



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК

Гүйцэтгэх захирал С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо

Утас: 90098901

Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Залруулсан алдаа.....	16
5.2 Төлбөрийн акт.....	17
5.3 Албан шаардлага.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СҮХБААТАР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Д.АЛТАНТУЯА
ТАНАА

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.08.25 № 121

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн "Нэгдсэн эмнэлэг"-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн "Нэгдсэн эмнэлэг"-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 чиглэлээр 12,312,715.0 мянган төгрөг байхаар төсөвлөсөн ба гүйцэтгэл 11,749,754.8 мянган төгрөг 95.4 %-тай байна.

Аудитын гол асуудал

Цалингийн нэмэгдэл урамшууллын зардал 172.7 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 20.1 сая төгрөг, нормативт зардал 212.5 сая төгрөг, хөрөнгө худалдан авалт 86.9 сая төгрөг албан томилот 6.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 18.4 сая төгрөгөөр илүү тооцсоныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,775,091,854.96	1,293,640,406.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,312,582.61	262,397,402.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,312,582.61	262,397,402.91
3121	Төгрөг	6,312,582.61	262,397,402.91
31211	Төрийн сангийн харилцах	1,263,001.15	258,887,402.91
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	3,510,000.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	5,049,581.46	-
33	АВЛАГА	2,107,408,022.80	60,212,193.31
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,104,253,684.80	57,762,000.00
335	Бусад авлага	3,154,338.00	2,450,193.31
3351	Байгууллагаас авах авлага	3,154,338.00	2,450,193.31
35	БАРАА МАТЕРИАЛ	661,371,249.55	971,030,810.14
351	Түүхий эд материал	268,040,966.07	622,642,968.79
35130	Эм боох материал	268,040,966.07	622,642,968.79
354	Хангамжийн материал	393,330,283.48	348,387,841.35
35410	Бичиг хэргийн материал	2,485,160.00	1,499,320.00
35420	Аж ахуйн материал	5,003,158.65	12,521,575.00
35440	Түлш, шатах тослох материал	9,775,750.20	14,331,565.00
35460	Хүнсний материал	11,234,283.51	24,573,555.36
35470	Бусад хангамжийн материал	364,831,931.12	295,461,825.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,442,540,187.55	13,306,160,799.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,442,540,187.55	13,306,160,799.36
392	Биет хөрөнгө	10,988,256,187.55	12,851,876,799.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,197,023,101.00	7,743,126,098.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(506,683,632.55)	(692,909,472.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	598,771,058.00	955,408,243.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(428,080,576.59)	(486,470,997.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,846,025,161.10	11,365,789,668.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,864,346,960.93)	(6,373,276,047.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	525,092,530.00	780,157,959.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(384,833,692.36)	(444,925,351.96)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(937,500.12)	(1,250,000.16)
39217	Ном	726,700.00	726,700.00
393	Биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,217,632,042.51	14,599,801,205.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,015,872,950.56	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,015,872,950.56	-
413	Өглөг	1,015,872,950.56	-
4136	Бусад өглөг	1,015,872,950.56	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,015,433,665.37	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	439,285.19	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,201,759,091.95	14,599,801,205.72
51	Засгийн газрын хувь оролцоо	13,201,759,091.95	14,599,801,205.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,682,328,865.24	3,682,328,865.24
51101	Өмч: - төрийн	3,682,328,865.24	3,682,328,865.24
512	Хуримтлагдсан үр дүн	6,160,148,478.59	7,558,190,592.36
51210	Өмнөх үеийн үр дүн	6,160,148,478.59	6,160,148,478.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,398,042,113.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,359,281,748.12	3,359,281,748.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,217,632,042.51	14,599,801,205.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,808,890,133.87	13,976,337,897.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,615,992,180.41	4,329,897,524.26
120	Нийтлэг татварын бус орлого	1,155,678,000.71	742,137,685.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,155,678,000.71	742,137,685.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,096,654.00	208,026,533.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,265,420.00	153,050,342.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,035,315,926.71	381,060,809.90
122	Тусламжийн орлого	2,460,314,179.70	3,587,759,838.80
122001	Хандив тусламж /дотоод/	2,460,314,179.70	3,587,759,838.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,192,897,953.46	9,646,440,373.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,339,973,220.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,339,973,220.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,041,797,877.46	15,900,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,346,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	788,086,157.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	219,365,720.46	15,900,000.00
1330	Төсвийн захирагчдаас	500,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	350,000,000.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	150,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,311,126,856.00	9,630,540,373.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,311,126,856.00	9,630,540,373.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,542,125,853.31	12,578,295,783.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,542,125,853.31	12,578,295,783.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,073,111,577.31	12,544,590,919.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,956,806,782.80	5,453,340,527.12
210101	Үндсэн цалин	2,965,926,675.09	3,307,264,971.20
210102	Нэмэгдэл	1,409,646,736.42	1,301,509,084.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,727,410.32	191,297,740.00
210104	Урамшуулал	385,505,960.97	653,268,731.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	697,518,500.00	683,849,027.87
210201	Тэтгэврийн даатгал	518,994,500.00	475,328,153.81
210202	Тэтгэмжийн даатгал	44,631,000.00	55,675,906.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,704,800.00	43,431,923.72
210204	Ажилгүйдлийн даатгал	8,926,200.00	9,944,900.85
210205	Эрүүл мэндийн даатгал	89,262,000.00	99,468,142.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	818,723,928.70	848,973,507.60
210301	Гэрэл, цахилгаан	104,496,488.00	88,592,693.72
210302	Түлш, халаалт	591,177,220.70	646,885,153.88

210303	Цэвэр, бохир ус	123,050,220.00	113,495,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	222,861,913.62	364,018,938.81
210401	Бичиг хэрэг	13,799,393.82	23,464,105.00
210402	Тээвэр, шатахуун	125,316,520.80	178,169,335.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199,570.00	4,982,984.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	81,894,629.00	67,755,832.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	651,800.00	89,646,681.63
2105	Нормативт зардал	3,932,065,744.58	3,063,137,548.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,573,110,638.15	2,741,333,811.55
210502	Хоол, хүнс	358,145,106.43	283,653,294.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	810,000.00	38,150,442.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,819,292.00	177,490,561.50
210604	Урсгал засвар	68,819,292.00	177,490,561.50
2107	Томилот, зочны зардал	5,854,000.00	52,637,790.00
210702	Дотоод албан томилот	5,854,000.00	52,637,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,568,514.95	84,010,511.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,212,760.00	68,766,468.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	874,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,912,425.00	1,769,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,624.00	719,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,296,281.95	2,390,000.00
210807	Газрын төлбөр	1,285,704.00	1,285,704.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,273,720.00	7,905,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,311,892,900.66	1,817,132,506.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	488,600.00	3,183,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,311,404,300.66	1,813,949,506.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	469,014,276.00	33,704,864.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	469,014,276.00	33,704,864.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	469,014,276.00	33,704,864.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,266,764,280.56	1,398,042,113.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,266,764,280.56	1,398,042,113.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,220,655,559.66	12,051,830,438.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,166,654.00	339,565,180.54
120	Нийтлэг татварын бус орлого	118,166,654.00	339,565,180.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,166,654.00	339,565,180.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,096,654.00	208,026,533.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	131,538,647.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,102,488,905.66	11,712,265,257.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,339,973,220.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,339,973,220.00	-

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034,034,514.46	56,841,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,346,000.00	14,490,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	776,922,794.00	21,608,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	222,765,720.46	20,743,200.00
1330	Төсвийн захирагчдаас	500,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	350,000,000.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	150,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,228,481,171.20	11,655,424,057.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,228,481,171.20	11,655,424,057.80
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,176,382,877.05	11,705,935,338.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,176,382,877.05	11,705,935,338.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,701,368,601.05	11,671,944,474.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,955,680,397.61	5,455,350,557.13
210101	Үндсэн цалин	2,964,800,289.90	3,294,534,989.81
210102	Нэмэгдэл	1,409,646,736.42	1,318,662,309.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,727,410.32	191,114,702.34
210104	Урамшуулал	385,505,960.97	651,038,555.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	697,518,500.00	682,940,828.36
210201	Тэтгэврийн даатгал	518,994,500.00	474,482,954.30
210202	Тэтгэмжийн даатгал	44,631,000.00	55,638,106.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,704,800.00	43,425,203.72
210204	Ажилгүйдлийн даатгал	8,926,200.00	9,943,220.85
210205	Эрүүл мэндийн даатгал	89,262,000.00	99,451,342.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	616,559,178.00	1,049,959,508.30
210301	Гэрэл, цахилгаан	102,265,738.00	89,578,693.72
210302	Түлш, халаалт	434,104,280.00	846,875,154.58
210303	Цэвэр, бохир ус	80,189,160.00	113,505,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	217,258,905.07	293,539,311.98
210401	Бичиг хэрэг	14,186,339.82	20,471,600.00
210402	Тээвэр, шатахуун	125,970,830.00	183,634,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,017,875.25	4,982,984.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,624,480.00	66,598,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,459,380.00	17,852,097.00
2105	Нормативт зардал	2,082,081,830.67	3,827,796,548.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,767,759,975.17	3,449,702,074.87
210502	Хоол, хүнс	307,690,355.50	356,894,653.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,631,500.00	21,199,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,651,600.00	192,568,309.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,947,100.00	19,221,000.00
210602	Тавилга	-	624,900.00
210604	Урсгал засвар	54,704,500.00	172,722,409.00
2107	Томилолт, зочны зардал	5,854,000.00	52,637,790.00
210702	Дотоод албан томилолт	5,854,000.00	52,637,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,275,589.70	111,998,621.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,212,760.00	97,580,418.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	874,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,912,425.00	1,769,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,624.00	719,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,975,076.70	2,550,000.00
210807	Газрын төлбөр	1,285,704.00	1,285,704.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,302,000.00	6,920,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	488,600.00	5,153,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	488,600.00	5,153,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	475,014,276.00	33,990,864.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	475,014,276.00	33,990,864.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	475,014,276.00	33,990,864.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	44,272,682.61	345,895,100.30
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,960,100.00	89,810,280.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,960,100.00	89,810,280.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,960,100.00	89,810,280.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,960,100.00	89,810,280.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,960,100.00)	(89,810,280.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,312,582.61	256,084,820.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,312,582.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,312,582.61	262,397,402.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(356,452,562.36)	(356,452,562.36)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	6,160,148,478.59	13,201,759,091.95
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	6,160,148,478.59	13,201,759,091.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	6,160,148,478.59	13,201,759,091.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,398,042,113.77	1,398,042,113.77
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	7,558,190,592.36	14,599,801,205.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,312,715,000.00	11,749,754,836.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,312,715,000.00	11,749,754,836.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,301,795,000.00	11,717,372,172.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,112,615,000.00	5,455,350,557.13
210101	Үндсэн цалин	3,989,003,100.00	3,294,534,989.81
210102	Нэмэгдэл	1,429,738,400.00	1,318,662,309.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,523,000.00	191,114,702.34
210104	Урамшуулал	478,350,500.00	651,038,555.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	801,576,900.00	682,940,828.36
210201	Тэтгэврийн даатгал	507,172,300.00	474,482,954.30
210202	Тэтгэмжийн даатгал	108,026,200.00	55,638,106.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	49,700,900.00	43,425,203.72
210204	Ажилгүйдлийн даатгал	12,425,200.00	9,943,220.85
210205	Эрүүл мэндийн даатгал	124,252,300.00	99,451,342.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,192,858,200.00	1,049,959,508.30
210301	Гэрэл, цахилгаан	89,706,700.00	89,578,693.72
210302	Түлш, халаалт	983,771,200.00	846,875,154.58
210303	Цэвэр, бохир ус	119,380,300.00	113,505,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	273,595,200.00	293,677,811.98
210401	Бичиг хэрэг	7,925,100.00	20,471,600.00
210402	Тээвэр, шатахуун	167,333,000.00	183,634,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,961,400.00	4,982,984.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	84,881,000.00	66,598,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,494,700.00	17,990,597.00
2105	Нормативт зардал	3,592,021,500.00	3,804,479,566.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,178,338,200.00	3,426,385,093.41
210502	Хоол, хүнс	383,540,900.00	356,894,653.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,142,400.00	21,199,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	181,875,000.00	268,750,089.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	80,733,400.00	104,517,680.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,063,900.00	-
210604	Урсгал засвар	95,077,700.00	159,232,409.00
2107	Томилолт, зочны зардал	45,893,100.00	52,637,790.00
210702	Дотоод албан томилолт	45,893,100.00	52,637,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,360,100.00	104,423,021.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,600,000.00	90,004,818.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,170,000.00	874,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,770,000.00	1,769,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,122,000.00	719,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,100,000.00	2,550,000.00
210807	Газрын төлбөр	1,304,000.00	1,285,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,894,100.00	6,920,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,000,000.00	5,153,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	5,153,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,920,000.00	32,382,664.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,920,000.00	32,382,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,920,000.00	32,382,664.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,312,715,000.00	12,010,889,238.34
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,117,816,700.00	11,655,424,057.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,117,816,700.00	11,655,424,057.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	194,898,300.00	339,565,180.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	194,898,300.00	208,026,533.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	131,538,647.54
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,263,001.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	262,397,402.91
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	330.00	330.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	255.00	255.00
620003	Үйлчлэх ажилтан	73.00	73.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн зорилго "Эерэг хандлагыг эрхэмлэн, иргэн бүрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг орчин үеийн техник, технологид тулгуурлан аюулгүй орчинд чанартай үзүүлнэ" гэсэн зорилгын хүрээнд чадварлаг мэргэшсэн хандлагатай эрүүл ажилтан, оношилгооны өндөр чадавхи бүхий тоног төхөөрөмж, ая тухтай аюулгүй орчин нөхцөл, сэтгэл ханамжтай эрхэм үйлчлүүлэгчийг үнэт зүйлээр тодорхойлон үйлүүлэгч төвтэй жишиг эмнэлэг болохоор үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны "Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" 190 дүгээр тушаал;
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны "Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай" 67/А/268, А/387/99 дугаар хамтарсан тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг гэж үзэж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 382,169.2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,312.6	262,397.4	256,084.8
Авлага	2,107,408.0	60,212.2	(2,047,195.8)
Бараа материал	661,371.2	971,030.8	309,659.6
Үндсэн хөрөнгө	11,442,540.2	13,306,160.8	1,863,620.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,217,632.0	14,599,801.2	382,169.2

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 256,084.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны зарцуулагдаагүй үлдэгдэл байна.
- Өмнөх оны төлбөрт үйлчилгээний 2,104,253.7 мянган төгрөгийн орлого он дамжин 2022 онд төвлөрсөн байна.
- Бараа материал данс 309,659.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас Сайдын тушаалаар үнэ төлбөргүй ирсэн эм, эмнэлгийн хэрэгсэл 245,744.4 мянган төгрөг, лабораторийн урвалж оношлуур 86,581.8 мянган төгрөг, глобал сангаас сүрьеэгийн тасагт үнэ төлбөргүй нийлүүлсэн эмийн үлдэгдэл 19,943.8 мянган төгрөгийн орлого нөлөөлөл үзүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгө данс 1,863,620.6 мянган төгрөгөөр өссөн нь хүчилтөрөгчийн үйлдвэр 546,103.0 мянган төгрөг, автомашин 356,637.2 мянган төгрөг, эмнэлгийн тоног төхөөрөмж 2,774,829.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9,410,204.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 9,410,204.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд дахин тодотгол хийгдэн 2,902,510.2 мянган төгрөгөөр нэмж төсөвлөсөн нь 2021 оны авлага өглөгийн төлөх санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийт 11,994,989.2 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс эрүүл мэндийн даатгалын сангаас 11,655,424.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 208,026.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 131,538.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Урсгал үйл ажиллагаанд 11,749,754.8 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 262,397.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мян.төг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	12,312,715.0	11,749,754.8	562,960.2	95.4%
НИЙТ		12,312,715.0	11,749,754.8	562,960.2	95.4%

Төлөвлөгөөний гүйцэтгэл 562,960.2 мянган төгрөгөөр буурсан буюу 95.4 хувьтай байгаа нь цалин 657,264.4 мянган төгрөг, НДШ-ийн зардал 18,631.6 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна. Цар тахал багасаж хөл хорио буурсантай холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгчид болон эмнэлгийн туслалцаа үйлчилгээ авч буй хүний тоо өссөнтэй холбоотойгоор нормативд зардал 212,458.1 мянган төгрөг, урсгал засварын зардал 86,875.1 мянган төгрөг, томилолтын зардал 6,744.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 14,062.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 32,382.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа, гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндуг аудит ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 188,674.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 132,072.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2¹, 15.2.3², 15.1.6³-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд зардлууд 55,707.3-141,157.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: халаалтын зардал 55,707.3 мянган төгрөгөөр өсч, хангамж бараа материалын зардал 141,157.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо нэмэгдсэнээр халаалтын хэрэгцээ өссөн ба нүүрсний тээврийн зардал нэмэгдсэнээр уг зардлын нэгжийн өртөг өссөн мөн нэмж хүчилтөрөгчийн үйлдвэр ашиглалтанд орсон нь зардлын өсөлтөд нөлөө үзүүлсэн байна.*
- *Эрүүл мэндийн яамнаас 4 машин хүлээн авч үйл ажиллагаанд хэрэглэх болсон нь шатахууны зардал нэмэгдсэн ба түлш, шатахууны үнийн нэмэгдэл хангамжийн зардлыг өсгөх шалтгаан болсон.*
- *Эрүүл мэндийн яамнаас их хэмжээгээр халдвар хамгааллын эм, эмийн хэрэгсэл тусламжаар орж ирсэн нь нөөцөд байгаа бараа материалын үлдэгдлийг огцом өсгөсөн байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

¹ нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

⁴ нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 383 мэдээллээс, хугацаандаа оруулсан 301 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 77, огт байршуулаагүй мэдээлэл 6 байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6⁴ дугаар зүйлийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 .Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	-	4	-	100
Төлбөрийн акт	1	12,438.6	1	11,577.2	93.1
Албан шаардлага	1	12,000.0	1	12,000.0	100
Нийт дүн	7	24,438.6		23,577.2	96.5

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 96,872.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг цахим баримтаар бүртгээгүй, бараа материалын дансанд 51 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэсэн, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 994 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй асуудлуудад 3 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Цалингийн зардлыг НД, ХХОАТ-ын тайланд илүү тайлагнасан 867.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулсан.

⁴ Шилэн дансны мэдээлэл

5.2 Төлбөрийн акт

Цалингаас 208.2 мянган төгрөгийн НДШ, 99.7 мянган төгрөгийн ХХОАТ илүү нийт 307.9 мянган төгрөгийг төсвөөс илүү шилжүүлсэн.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 6, мэдээллийн хугацаа нь болоогүй 5, огт байршуулаагүй мэдээлэл 1 байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөөгүй давтан зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн: зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв

5.4 Зөвлөмж

5.4.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 994 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17, түүний праграфын 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

5.4.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд 51 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллаар буруу бүртгэгдсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж, санхүүгийн тайланг засварлах

5.4.3 Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Худалдан авалтын ажил гүйлгээний баримтыг /<https://ebarimt.mn/> цахим төлбөрийн системд бүрэн шивэгдээгүй байхад зарлагын гүйлгээ хийгдэж байна.

Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд тухай бүр бүртгэнэ", НББ-ийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг биелүүлж хэрэгжүүлж, ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлыг илүү НД болон ХХОАТ-ын тайланд тусгасан	1	867.5			1	867.5	1	867.5				
Дүн	1	867.5			1	867.5	1	867.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Илүү суутгал хийж цалин дутуу олгосон	1	307.9	1	307.9								
Өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгийг стандартын дагуу бүртгээгүй	1						1					
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн	1	68,614.6					1	68,614.6				
Цахим баримтаар зардал нотлоогүй	1						1					
Дүн	4	68,922.5	1	307.9			3	68,922.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
/мянган төгрөгөөр/										
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн болон мэдээлээгүй	1						1		1	
Дүн	1						1		1	